



**ХЭНТИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 07 сарын 18 өдөр

Дугаар А/109

Мөрөн сум

**Тамхины тусгай зөвшөөрөл
олгох тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3.4, заалт тамхины хяналтын тухай хуулийн 6.7.14, 7.3, 7.9 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Худалдааны газрын стандартын шаардлага хангасан, Ерөнхий боловсролын сургуулийн 500 метрийн тойргоос гадагш байрлах, "Элит Мандал" ХХК-д тамхи худалдаалах тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар олгосугай.

2.Тусгай зөвшөөрөл олгогдсон аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Хөдөө аж ахуйн тасгийг түр орлон гүйцэтгэгч /Ш.Баасандорж/, татварын улсын байцаагч /Ж.Алтанцэцэг/, хэсгийн төлөөлөгч Цагдаагийн ахмад /Г.Сэргэлэнбаатар/ нарт үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.БАТЦООЖ

